



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2025/085/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

2025 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.08.25 № 131  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГУРВАНТЭС СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Э.АЛДАРБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурвантэс сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан, албан тушаалын тодорхойлолтгүй ажилтан цалинжуулсан, ур чадварын нэмэгдлийг журмын дагуу олгоогүй, цалин хөлс, албан томилолтыг зөрүүтэй олгосон, хувь хүний орлогын албан татвар тооцоогүй, тендер шалгаруулалтгүй худалдан авалт хийсэн зэрэг нийт 91,259.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.12, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын түүхт 70 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2,892,210.0 мянган төгрөгөөр цэнгэлдэх хүрээлэн баригдсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 625,179.9 мянган төгрөгийн барилга байгууламж, спорт заал болон ёслол хүндэтгэлийн өргөөнд 754,460.0 мянган төгрөгийн их засвар, 27,854,600.0 мянган төгрөгийн 15 километр автозам, багийн засаг дарга нарт 246,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэнийг хөрөнгийн бүртгэлд тусгасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 130 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.9 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>803,718,828.00</u></b>	<b><u>757,442,717.14</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>39,941,645.00</b>	<b>37,536,645.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	39,941,645.00	37,536,645.00
<b>3351</b>	Байгууллагаас авах авлага	19,693,800.00	17,288,800.00
<b>3352</b>	Хувь хүмүүсээс авах авлага	20,247,845.00	20,247,845.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	<b>1,939,400.00</b>
<b>34600</b>	Урьдчилж гарсан зардал	-	1,939,400.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>763,777,183.00</b>	<b>717,966,672.14</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>434,412,380.00</b>	<b>213,330,680.00</b>
<b>35110</b>	Тусгай зориулалттай материал	434,412,380.00	213,330,680.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>235,602,003.00</b>	<b>404,695,928.14</b>
<b>35410</b>	Бичиг хэргийн материал	3,978,375.00	4,289,975.00
<b>35420</b>	Аж ахуйн материал	53,797,501.00	67,035,495.00
<b>35440</b>	Түлш, шатах тослох материал	16,414,127.00	19,831,753.99
<b>35470</b>	Бусад хангамжийн материал	161,412,000.00	313,538,704.15
<b>35600</b>	Мал амьтад	93,762,800.00	99,940,064.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>9,775,260,285.97</u></b>	<b><u>42,297,012,281.16</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>9,775,260,285.97</b>	<b>42,297,012,281.16</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>9,727,989,135.97</b>	<b>42,249,503,631.12</b>
<b>39201</b>	Барилга, байгууламж, орон сууц	8,099,019,766.05	10,921,029,075.05
<b>39202</b>	Хуримтлагдсан элэгдэл	(2,487,159,783.67)	(2,971,476,724.18)
<b>39203</b>	Авто-тээврийн хэрэгсэл	310,399,871.00	490,572,071.00
<b>39204</b>	Хуримтлагдсан элэгдэл	(128,279,675.17)	(101,096,178.78)
<b>39205</b>	Машин тоног төхөөрөмж (компьютер)	999,981,933.35	1,220,883,004.28
<b>39206</b>	Хуримтлагдсан элэгдэл	(226,305,984.34)	(301,656,958.69)
<b>39207</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил	187,744,541.79	247,773,191.79
<b>39208</b>	Хуримтлагдсан элэгдэл	(79,707,571.07)	(89,277,833.07)
<b>39209</b>	Зам, гүүрийн байгууламж	2,952,088,598.00	32,630,141,374.00
<b>39210</b>	Хуримтлагдсан элэгдэл	(404,432,779.83)	(647,230,829.12)
<b>39213</b>	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	25,000,000.00	25,000,000.00
<b>39214</b>	Бусад үндсэн хөрөнгө	586,225,718.13	971,454,904.34
<b>39215</b>	Хуримтлагдсан элэгдэл	(106,585,498.27)	(146,611,465.50)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>47,271,150.00</b>	<b>47,508,650.04</b>
<b>39301</b>	Программ хангамж	2,162,500.00	653,750.00
<b>39302</b>	Хуримтлагдсан элэгдэл	(1,808,750.00)	(62,499.96)
<b>39303</b>	Бусад биет бус хөрөнгө	46,917,400.00	46,917,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>10,578,979,113.97</u></b>	<b><u>43,054,454,998.30</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>196,163,305.38</u></b>	<b><u>19,725,843.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>196,163,305.38</b>	<b>19,725,843.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	196,163,305.38	19,725,843.00
<b>41310</b>	Ажилчидтай холбогдсон өглөг	347,405.38	-
<b>41340</b>	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	195,815,900.00	19,725,843.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>10,382,815,808.59</u></b>	<b><u>43,034,729,155.30</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	10,382,815,808.59	43,034,729,155.30
<b>511</b>	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,023,649,776.03	1,023,649,776.03
<b>51101</b>	Өмч: - төрийн	1,023,649,776.03	1,023,649,776.03
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>8,982,341,294.41</b>	<b>41,634,254,641.12</b>
<b>51210</b>	Өмнөх үеийн үр дүн	8,982,341,294.41	8,982,341,294.41
<b>51220</b>	Тайлант үеийн үр дүн	-	32,651,913,346.71
<b>51300</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,824,738.15	376,824,738.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>10,578,979,113.97</u></b>	<b><u>43,054,454,998.30</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>7,999,022,706.00</b>	<b>43,873,289,142.42</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,000,000.00</b>	<b>29,544,558,788.42</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>90,000,000.00</b>	<b>29,544,558,788.42</b>
<b>120004</b>	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,000,000.00	29,395,815,992.27
<b>1200041</b>	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000,000.00	-
<b>1200042</b>	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	91,000,000.00
<b>1200045</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	29,304,815,992.27
<b>1200018</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал		148,742,796.15
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>7,909,022,706.00</b>	<b>14,328,730,354.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>643,991,306.00</b>	<b>7,035,785,354.00</b>
<b>131103</b>	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	476,054,574.00	6,902,943,001.00
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,543,192.00	7,168,110.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	108,393,540.00	125,674,243.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>7,265,031,400.00</b>	<b>7,292,945,000.00</b>
<b>132001</b>	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,265,031,400.00	7,292,945,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,637,169,408.51</b>	<b>11,205,792,337.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,637,169,408.51</b>	<b>5,657,960,260.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,530,758,662.57</b>	<b>4,031,514,490.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>495,785,014.43</b>	<b>836,132,734.58</b>
<b>210101</b>	Үндсэн цалин	264,466,232.98	408,120,831.89
<b>210102</b>	Нэмэгдэл	143,175,059.02	294,665,111.96
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	22,863,000.00	42,209,257.93
<b>210104</b>	Урамшуулал	65,280,722.43	83,280,064.56
<b>210105</b>	Гэрээт ажлын хөлс	-	7,857,468.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,544,369.35</b>	<b>99,942,388.58</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	42,204,216.82	69,236,489.34
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	4,931,781.50	8,137,879.67
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	3,883,638.48	4,237,389.93

210204	Ажилгүйдлийн даатгал	764,955.67	3,409,982.28
210205	Эрүүл мэндийн даатгал	7,759,776.88	14,920,647.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>128,300,038.32</b>	<b>154,655,475.66</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,405,645.62	18,062,033.16
210302	Түлш, халаалт	108,543,121.50	134,107,924.50
210303	Цэвэр, бохир ус	2,351,271.20	2,485,518.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>237,153,108.11</b>	<b>163,245,733.95</b>
210401	Бичиг хэрэг	13,982,430.00	23,361,300.00
210402	Тээвэр, шатахуун	98,586,292.11	63,226,959.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,366,190.00	5,679,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,100,000.00	14,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	94,618,196.00	56,877,524.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	10,500,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>56,086,250.00</b>	<b>93,903,370.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	23,950,000.00
210604	Урсгал засвар	56,086,250.00	69,953,370.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>25,424,000.00</b>	<b>31,612,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	25,424,000.00	31,612,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>715,252,340.00</b>	<b>1,178,552,407.06</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	715,252,340.00	1,178,552,407.06
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,813,213,542.36</b>	<b>1,473,470,380.91</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,933,309,553.67	400,923,483.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,871,458.00	11,827,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	874,032,530.69	1,060,719,197.91
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>20,000,000.00</b>	<b>45,040,000.00</b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>20,000,000.00</b>	<b>45,040,000.00</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000,000.00	45,040,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,086,410,745.94</b>	<b>1,581,405,769.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>135,211,149.19</b>	<b>90,170,999.54</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,445,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,462,370.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	112,765,549.19	52,838,629.54
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,764,141.72</b>	<b>3,253,750.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,764,141.72	3,253,750.98
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,943,435,455.03</b>	<b>1,487,981,019.28</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,943,435,455.03	1,487,981,019.28
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>5,547,832,077.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>5,547,832,077.00</b>
223001	Бусад хөрөнгө	-	5,547,832,077.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>361,853,297.49</u></b>	<b><u>32,667,496,804.88</u></b>

225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	15,583,458.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,808,458.17
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	9,775,000.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(15,583,458.17)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>361,853,297.49</u></b>	<b><u>32,651,913,346.71</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>7,999,022,706.00</u></b>	<b><u>14,422,135,354.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,000,000.00</b>	<b>91,000,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>90,000,000.00</b>	<b>91,000,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	90,000,000.00	91,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	91,000,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>7,909,022,706.00</b>	<b>14,331,135,354.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	643,991,306.00	7,038,190,354.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	476,054,574.00	6,905,348,001.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,543,192.00	7,168,110.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	108,393,540.00	125,674,243.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>7,265,031,400.00</b>	<b>7,292,945,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,265,031,400.00	7,292,945,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>5,519,302,175.00</u></b>	<b><u>4,533,394,188.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,519,302,175.00</b>	<b>4,533,394,188.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,411,417,288.56</b>	<b>2,906,948,418.20</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>494,180,992.26</b>	<b>836,480,139.96</b>
210101	Үндсэн цалин	262,862,210.81	408,468,237.27
210102	Нэмэгдэл	143,175,059.02	294,665,111.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,863,000.00	42,209,257.93
210104	Урамшуулал	65,280,722.43	83,280,064.56
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,857,468.24
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,989,484.58</b>	<b>99,942,388.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,204,216.82	69,236,489.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,931,781.50	8,137,879.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,838,967.33	4,237,389.93
210204	Ажилгүйдлийн даатгал	907,484.97	3,409,982.28
210205	Эрүүл мэндийн даатгал	9,107,033.96	14,920,647.36

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>128,300,038.32</b>	<b>154,655,475.66</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,405,645.62	18,062,033.16
210302	Түлш, халаалт	108,543,121.50	134,107,924.50
210303	Цэвэр, бохир ус	2,351,271.20	2,485,518.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>111,878,247.00</b>	<b>134,661,762.00</b>
210401	Бичиг хэрэг	16,274,660.00	23,672,900.00
210402	Тээвэр, шатахуун	56,565,854.00	67,170,112.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,366,190.00	5,679,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,100,000.00	14,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,571,543.00	24,038,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>57,762,050.00</b>	<b>95,403,370.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	25,450,000.00
210604	Урсгал засвар	57,762,050.00	69,953,370.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>25,424,000.00</b>	<b>31,612,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	25,424,000.00	31,612,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,076,545,961.40</b>	<b>1,318,285,839.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,076,545,961.40	1,318,285,839.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>456,336,515.00</b>	<b>235,907,443.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,465,057.00	224,079,743.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,871,458.00	11,827,700.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>20,000,000.00</b>	<b>45,040,000.00</b>
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000,000.00	45,040,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000,000.00	45,040,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,087,884,886.44</b>	<b>1,581,405,769.80</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,280,289.69	90,170,999.54
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,870,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,445,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	14,462,370.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	111,834,689.69	52,838,629.54
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,169,141.72</b>	<b>3,253,750.98</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,169,141.72	3,253,750.98
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,943,435,455.03	1,487,981,019.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,943,435,455.03	1,487,981,019.28
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,479,720,531.00</u></b>	<b><u>9,888,741,166.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,479,720,531.00</b>	<b>9,888,741,166.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,479,720,531.00</b>	<b>9,888,741,166.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,479,720,531.00</b>	<b>9,888,741,166.00</b>
223001	Бусад хөрөнгө	2,026,964,479.65	5,605,277,507.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	452,756,051.35	4,283,463,659.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,479,720,531.00)</u>	<u>(9,888,741,166.00)</u>
---	---	---------------------------	---------------------------

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,023,649,776.03	376,824,738.15	7,673,573,974.92	9,074,048,489.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,023,649,776.03	376,824,738.15	7,673,573,974.92	9,074,048,489.10
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,308,767,319.49	1,308,767,319.49
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,023,649,776.03	376,824,738.15	8,982,341,294.41	10,382,815,808.59
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,023,649,776.03	376,824,738.15	8,982,341,294.41	10,382,815,808.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,023,649,776.03	376,824,738.15	8,982,341,294.41	10,382,815,808.59
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	32,651,913,346.71	32,651,913,346.71
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,023,649,776.03	376,824,738.15	41,634,254,641.12	43,034,729,155.30

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,164,728,900.00	5,895,963,980.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,446,398,900.00	2,690,070,450.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,294,010,100.00	2,597,627,860.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	879,320,900.00	772,131,465.37
210101	Үндсэн цалин	461,027,900.00	408,468,237.27
210102	Нэмэгдэл	313,320,200.00	294,665,111.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,252,800.00	42,209,257.93
210104	Урамшуулал	38,040,000.00	18,931,389.97
210105	Гэрээт ажлын хөлс	14,680,000.00	7,857,468.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,915,100.00	92,128,858.69
210201	Тэтгэврийн даатгал	74,742,300.00	63,769,935.76
210202	Тэтгэмжийн даатгал	8,793,200.00	7,494,755.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,985,400.00	3,915,827.94
210204	Ажилгүйдлийн даатгал	3,807,800.00	3,133,524.19
210205	Эрүүл мэндийн даатгал	17,586,400.00	13,814,815.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,977,800.00	154,655,475.66
210301	Гэрэл, цахилгаан	24,000,000.00	18,062,033.16
210302	Түлш, халаалт	149,727,600.00	134,107,924.50
210303	Цэвэр, бохир ус	4,250,200.00	2,485,518.00
2104	Хангамж, бараа материалын зардал	158,859,000.00	130,394,152.00
210401	Бичиг хэрэг	30,000,500.00	23,672,900.00
210402	Тээвэр, шатахуун	81,000,000.00	62,902,502.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,758,500.00	5,679,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,100,000.00	14,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,000,000.00	24,038,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>106,437,200.00</b>	<b>95,403,370.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,957,200.00	25,450,000.00
210604	Урсгал засвар	70,480,000.00	69,953,370.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>43,463,000.00</b>	<b>30,762,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	43,463,000.00	30,762,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,665,037,100.00</b>	<b>1,218,824,839.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,665,037,100.00	1,218,824,839.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>153,000,000.00</b>	<b>103,327,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,500,000.00	91,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	46,500,000.00	11,827,700.00
212	<b>ТАТААС</b>	70,000,000.00	45,040,000.00
2122	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>70,000,000.00</b>	<b>45,040,000.00</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	70,000,000.00	45,040,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>82,388,800.00</b>	<b>47,402,590.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	82,388,800.00	47,402,590.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,462,400.00	14,462,370.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,600,000.00	10,070,220.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,718,330,000.00</b>	<b>3,205,893,530.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	3,718,330,000.00	3,205,893,530.00
223001	Бусад хөрөнгө	3,718,330,000.00	3,205,893,530.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7,164,728,900.00	5,895,963,980.72
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	7,058,228,900.00	5,804,963,980.72
132001	Орон нутгийн төсвөөс	7,058,228,900.00	5,804,963,980.72
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	106,500,000.00	91,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106,500,000.00	91,000,000.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	25	27
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	12	14
620003	Үйлчлэх ажилтан	5	5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,038,190,354.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>352,088,967.02</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>309,320,557.48</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>64,348,674.59</b>
210104	Урамшуулал	64,348,674.59

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>7,813,529.89</b>
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	5,466,553.58
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	643,123.94
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	321,561.99
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	276,458.09
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	1,105,832.29
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,267,610.00</b>
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	4,267,610.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>850,000.00</b>
<b>210702</b>	Дотоод албан томилолт	850,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>99,461,000.00</b>
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,461,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>132,579,743.00</b>
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	132,579,743.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,768,409.54</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,768,409.54</b>
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,768,409.54
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,253,750.98</b>
<b>213503</b>	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,253,750.98
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,682,847,636.00</b>
<b>2200</b>	Дотоод эх үүсвэрээр	6,682,847,636.00
<b>223001</b>	Бусад хөрөнгө	3,790,637,240.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>7,038,190,354.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,038,190,354.00</b>
<b>131103</b>	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,905,348,001.00
<b>131104</b>	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,168,110.00
<b>131105</b>	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	125,674,243.00

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 488,901.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

**Залруулсан алдаа:**

- Мөнгөн гүйлгээний биет бус хөрөнгө худалдан авах зардлыг, үндсэн хөрөнгийн тайлангийн худалдаж авсан хөрөнгийн бүртгэлээс 16,666.9 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгө өмчийн дүн, өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын хувь оролцоо 19,725.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө элэгдэл зардлын дүнг, үндсэн хөрөнгөд 2,750.0 мянган төгрөг, түлш халаалтын зардал уг өглөгийн бүртгэл 7,489.0 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Үндсэн хөрөнгийн тайлангаас 5,808.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг дансны бүртгэлээс хасахдаа санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэсэн,
- Үнэ төлбөргүй хүлээн авсан 425,084.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Цалингийн өглөгийн бүртгэлийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшилтай тулган баталгаажуулахад 8,244.3 мянга, гэрэл цахилгааны зардлыг 1,193.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн
- "Бэсгэ үнэлгээ ХХК"-иар барилгын төсөв, үнэлгээний тайлан боловсруулах хамтран ажиллах гэрээг байгуулж 1,939.4 мянган төгрөг олгон шууд зардлаар бүртгэсэн нь УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар илэрсэн нийт 131,498.6 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж 4,138.7 мянган төгрөгт төлбөрийн акт, 92,409.9 мянган төгрөгт албан шаардлага, 34,950.0 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

### **3.2 Төлбөрийн акт**

1. Ээлжийн амралтын олговрыг олгоход 1 ажилтанд 3 хоног буюу 234,930 төгрөгийн амралтын хоногийг давхардуулан олгосон, ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтанд ажилласан хугацаанд ногдох олговрыг 8 хоног буюу 985,224 төгрөг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8 "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: 1/ ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох, 2/ ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

2. Буцалтгүй тусламж олгохдоо 100,000 төгрөгийн албан татвар тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,...", Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралт "Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-д "Суутган төлөгч нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг зөвхөн тухайн байгууллагын баримт бичиг, шийдвэрийг үндэслэн олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг албан татвараас чөлөөлөхгүй" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3. Зургаан албан хаагчийг АЗ сургалтад хамруулан 866,700 төгрөгийн төлбөрийг төлсөн боловч сертификат авсан нь баримтаар нотлогдохгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

4. Жолоочийн тооцоогоор Toyota Land Cruiser маркийн 2000 ӨМҮ дугаартай автомашин 181,3 литр буюу 494,868 төгрөг, toyota Land Cruiser маркийн 5142 ӨМӨ дугаартай автомашин 24.2 литр буюу 65,984 төгрөг, УАЗ 220695 маркийн, 0201 ӨМА 25.7 литр буюу 70,095 төгрөгөөр тус тус нормоос хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам тээврийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал "Жишиг норм батлах тухай"-ын 1."Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг 1 дүгээр хавсралттай тус тус нийцээгүй байна.

5. Засаг даргын Тамгын газрын нэрэмжит сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, тэмээн сүргийн баярын хулдаасан хэвлэлд 1,321,000 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### **3.2 Албан шаардлага**

1. Оны эхнээс 3 албан тушаалтныг албан тушаалын тодорхойлолтгүй ажиллуулсан, 2024 оны төсвийн төсөлд тусгаагүй 2 ажилтныг гэрээгээр ажиллуулсан зэрэг нийт 53,288,992 төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Нэг шийдвэрээр 6 албан тушаалтанд сар бүр ур чадварын нэмэгдлийг тогтмол 25 хувиар тооцсон, нэмэгдэл хөлс тооцож олгох хуудасгүй илүү цагийн хөлс зэрэгт нийт 21,057,157 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаарын тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам", 4 дүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Албан томилолтын томилсон хоног бичээгүй 4,834,000 төгрөгийг олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн,

зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын Хоёр. "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр"-ын заалттай тус тус нийцээгүй байна.

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Цагдаагийн тасагт 4,394,632 төгрөгийн тээвэр шатахууны зардал, шатахуун худалдан борлуулах үйл ажиллагаа явуулдаггүй Эк Чук Ок ХХК-тай гэрээ байгуулан 8,096,814 төгрөг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 тоот хамтарсан тушаалын хавсралт "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын Хоёр. Хөрөнгийн зарцуулалт 7-д "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна. Үүнд 3/ сум, дүүргийн нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилох, урамшуулах"-ын заалттай тус тус нийцээгүй байна.

5. Өөр байгууллагад шилжин ажилласан албан хаагчид ажилласан хугацаанд ногдох 5.5 хоног буюу 738,375 төгрөгийн амралтын олговрыг олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8 "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: 1/ ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:** Өөрийн байгууллагад хамааралгүй 19,950,000 төгрөгийн эмнэлгийн урвалж оношлуурыг, багаж техник хэрэгслийн зардалд төлөвлөж шилжүүлсэн, Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах 10,000,000 төгрөгийн дэмжлэгийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас, 5,000,000 төгрөгийн айл өрхүүдийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын үйлчилгээний зардлыг бусад хураамжаас зарцуулж эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### **2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдлийг ил тод байршуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 "Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье





		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>														
1	Засаг даргын Тамгын газрын нэрэмжит сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, тэмээн сүргийн баярын хулдаасан хэвлэлд 1.3 сая төгрөг зарцуулсан	1	1,321.0	1	1,321.0										
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,321.0</b>	<b>1</b>	<b>1,321.0</b>										
	<b>НИЙТ ДҮН</b>	12	131,498.6	5	4,138.7	5	92,409.9	2	34,950.0						

